



МОНГОЛ УЛС

Төрийн тэргүүн: **Цахиагийн Элбэгдорж**
Засгийн газрын тэргүүн: **Жаргалтулгын Эрдэнэбат**
(7 дугаар сард Чимэдийн Сайханбилэгийн оронд томилогдсон)

6 дугаар сард болсон парламентын сонгуулиар сөрөг хүчин байсан Монгол Ардын Нам дийлэнх суудлыг авсан. Шинэ байгуулагдсан Засгийн газар өмнөх парламентын баталсан таван хуулийн хэрэгжилтийг хойшлуулсан ба үүнд цаазаар авах ялыг халсан Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга) багтсан байна. Засгийн газар хүний эрхийн хамгаалагчдыг төрийн байгууллага болон төрийн бус этгээдийн халдлага, заналхийллээс хамгаалж чадсангүй. Эрүүдэн шүүх болон бусад зүй бус харьцаа түр саатуулах газарт түгээмэл тархсан. Хууль тогтоомж нь олон улсын хууль, хэм хэмжээнд нийцээгүйн улмаас Нийслэл Улаанбаатар хотын оршин суугчдын шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрх зөрчигдөж, албадан нүүлгэлтэнд өртөх эрсдэлтэй байна.

ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ

Нийслэл Улаанбаатар хотод хот дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжээд багагүй хугацаа өнгөрсөн боловч холбогдох хууль эрх зүй, бодлогууд хожимдон гарч байна. Улаанбаатар хотын гэр хороолол (нийгмийн болон инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдоогүй гэр, байшингаас бүрдсэн оршин суух газар)-ыг өргөн хамарсан хот дахин төлөвлөлт нь хотын төлөвлөгдөөгүй хүн амын өсөлт болон нэмэгдэж байгаа бохирдлын асуудлыг шийдвэрлэхээр 10 гаруй жилийн өмнөөс эхэлсэн.¹ Гэвч төрөөс тодорхой, шаардлага хангасан зохицуулалт хийгээгүй, үр дүнтэй санал солилцох явц байхгүй, хяналт тавиагүй нь дахин төлөвлөлтөд

хамрагдаж буй иргэдийн эрх ялангуяа шаардлагад нийцсэн орон байртай байх эрх зөрчигдөхөд хүргэсэн байна.

Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн ашиглалтын шаардлага хангахгүй хуучирч өмхөрсөн байранд амьдардаг хөгжлийн бэрхшээлтэй иргэн, бага насны хүүхдүүдтэй айл өрхүүд 2015 оны өвөл гадаа -30°C хүйтэнд төвийн халаалтгүй байрандаа өвөлжсөн нь дахин төлөвлөлтийн төлөвлөгөө оршин суугчдад гамшигт үр нөлөө үзүүлсэн нэгэн жишээ юм. Эрх баригчид тус байрны зарим оршин суугчийг 10 дугаар сард түр орон байраар хангасан ч гомдлоо барагдуулах механизм болон үр дүнтэй хамгаалалт байхгүйгээс тэд хүний эрхийн зөрчилд өртөх эрсдэлтэй байна.²

ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАГЧ

Хүний эрхийн хамгаалагчид төрийн болон төрийн бус этгээдийн зүгээс үзүүлж буй сэтгэл зүйн болон бие махбодийн халдлага, заналхийллэд өртсөөр байна. Ирвэс хамгаалах сангийн байгаль орчны идэвхтэн Төмөрсүхийн Лхагвасүмбэрэлийн 2015 оны сүүлчээр сэжиг бүхий байдалд нас барсан хэргийн мөрдөн байцаалт үргэлжилж байна. Хүний Эрхийн Үндэсний Комиссоос ТББ-уудын тухай хууль болон бусад дотоодын хуулиуд нь хүний эрхийн хамгаалагчийн эрхийг бүрэн хамгаалж чадаагүй гэж мэдээллээ.

ЭРҮҮ ШҮҮЛТ БА БУСАД ЗҮЙ БУС ХАРЬЦАА

Хорих газарт эрүү шүүлт болон зүй бус харьцаа түгээмэл хэвээр байна. Эрх баригчид хоригдогсдыг айлган сүрдүүлэх, гэр бүл, өмгөөлөгчтэйгээ уулзахад нь бэрхшээл учруулахын тулд удаа дараа хорих төвүүдийн хооронд шилжүүлэх эсвэл орон гэрээс нь хол байрлах хорих газарт хорьж байна.

¹ Хангалтгүй хэрэгжүүлж байгаа нь - Монгол улсын нийслэл Улаанбаатар хот: Орон байртай байх эрх (ASA 30/4933/2016)

² Монгол улс: 200 гаруй хүн орон байргүй болох эрсдэлтэй байна (ASA 30/3743/2016) болон нэмэлт мэдээллийг (ASA 30/4793/2016) –ээс үзнэ үү.

Эмнести Интернэшнл нь хүний эрхийн зөрчлийг төгсгөл болгохын төлөө кампанит ажил өрнүүлдэг 150 гаруй орны 7 сая гаруй гишүүд, дэмжигчид, хүний эрхийн хамгаалагчдыг эгнээндээ нэгтгэсэн дэлхийн хөдөлгөөн юм.

Бидний хүсэл Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон бусад олон улсын жишиг хэмжээнд заасан хүний эрх, эрх чөлөөг хүн бүрт адил тэгш эдлүүлэхэд оршино.

Бид аливаа засгийн газар, улс төрийн үзэл бодол, эдийн засаг болон шашны үзлээс ангид байж, ихэнхдээ гишүүд, олон нийтийн хандиваар санхүүждэг.

Монголын Эмнести Интернэшнл
Хаяг: Сүхбаатар дүүрэг, 6-р хороо,
Их сургуулийн гудамж, #АВ центрийн
5 давхар 503 тоот
Утас/Факс: 976-7000-4705
aimncc@magicnet.mn
www.amnesty.mn